



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 4/181

Номгон

“Ковид-19” цар тахлын үед дайчлагдан ажилласан анагаахын оюутан, эмнэлгийн ажилтан, жолооч нарт ажлын хөлс олгох тухай

Монгол Улс коронавирус (COVID-19)-ын халдварыг дотооддоо алдаж, улмаар халдварын тохиолдол нэмэгдэн, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, онцгой нөхцөл байдал үүссэн үед иргэд, олон нийтийн дунд халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, шинжилгээнд хамруулах, тандалт судалгаа хийх үйл ажиллагаанд идэвх зүтгэлтэй ажилласан анагаахын сургуулийн оюутан, эмнэлгийн ажилтан, жолооч нарыг урамшуулах зорилгоор

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1, “Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1 дүгээр бүлгийн 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Онцгой нөхцөл байдлын үед иргэд олон нийтийн дунд коронавирусын халдвар илрүүлэх шинжилгээ, тандалт судалгаа хийж ажилласан анагаахын сургуулийн оюутан, эмнэлгийн ажилтан, жолооч нарт 12.790.970/ арван хоёр сая долоон зуун ерэн мянга есөн зуун далан/ төгрөгийн ажлын хөлсийг олгосугай.

2. Дээрх ажлын хөлсийг тооцооллын дагуу жагсаалтаар олгож, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т үүрэг болгосугай.

3. Анагаахын сургуулийн оюутан, эмнэлгийн ажилтан, жолооч нарт олгох 12.790.970/ арван хоёр сая долоон зуун ерэн мянга есөн зуун далан/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгальмаа)-т зөвшөөрсүгэй.

601210109

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН